

LEGAL NEWSLETTER

2024 July №47

AKP Law Firm

Бид энэ оны 7 дугаар сард батлагдсан онцлох хууль, УИХ-ын болон Засгийн Газрын тогтоолыг танилцуулж байна.

I. БАТЛАГДСАН ХУУЛИУД:

Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгууль зохион байгуулагдсантай холбоотойгоор дараах хоёр хуулийг баталж Засгийн газраа шинээр байгуулав.

1.1. ЗАСГИЙН ГАЗРЫН БҮТЦИЙН ТУХАЙ ХУУЛЬ

- Энэ хууль нь 2024 оны 07 дугаар сарын 10-ны өдөр батлагдан, тус өдрөөс хэрэгжиж эхэллээ.
- Уг хуулиар өмнөх Засгийн газрын бүтцийг өөрчилж, дараах 16 яамдыг байгуулав.

Ерөнхий чиг үүргийн яамд:

1. Эдийн засаг, хөгжлийн яам
2. Гадаад харилцааны яам
3. Сангийн яам
4. Хууль зүй, дотоод хэргийн яам

Чиглэлийн яамд:

5. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам
6. Батлан хамгаалах яам
7. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам
8. Боловсролын яам
9. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
10. Зам, тээврийн яам
11. Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам
12. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам
13. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
14. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам
15. Эрчим хүчний яам
16. Эрүүл мэндийн яам

1.2. ЗАСГИЙН ГАЗРЫН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ТУХАЙ ХУУЛЬ

- Энэ хууль нь 2024 оны 07 дугаар сарын 10-ны өдөр батлагдан, тус өдрөөс хэрэгжиж эхэллээ.
- Энэ хуулиар Засгийн газар нь Ерөнхий сайд болон 22 сайдын бүрэлдэхүүнтэй байхаар тогтоов.
- Яамгүй сайд нар нь
 - Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
 - Хяналт, үнэлгээний Үндэсний хороо
 - Боомтын сэргэлтийн Үндэсний хороо
 - 20 минутын хот Үндэсний хорооны даргаар тус тус ажиллана.

II. НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРСОН ХУУЛИУД:

Засгийн газрын шинэчилсэн бүтэц, бүрэлдэхүүнтэй холбоотойгоор доорх хуулиуд дараах байдлаар өөрчлөгджээ. Эдгээр өөрчлөлтүүд бүгд 2024 оны 07 дугаар сарын 10-ны өдөр батлагдан, тус өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн.

2.1. ӨРСӨЛДӨӨНИЙ ТУХАЙ ХУУЛЬ

Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар



Монополын эсрэг газар

Өрсөлдөөний тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, өрсөлдөөний бодлогыг улсын хэмжээнд хэрэгжүүлэх, аж ахуй эрхлэгч, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага болох “Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар” нь “Монополын эсрэг газар” болон өөрчлөгдсөн байна.

2.2. ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬ

- “Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах асуудал эрхэлсэн Монгол Улсын сайд” нь түүнд хууль тогтоомжоор харьяалуулсан байгууллагын төсвийн ерөнхийлөн захирагч байсан бол “20 минутын хотын асуудал эрхэлсэн Монгол Улсын сайд” нь холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч болсон. (§14.1.9)
- “Олимп, нийтийн биеийн тамир, спортын сайд” нь түүнд хууль тогтоомжоор харьяалуулсан байгууллагын төсвийн ерөнхийлөн захирагч байсан бол “Хяналт, үнэлгээний асуудал эрхэлсэн Монгол Улсын сайд” нь холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч болсон. (§14.1.10)

III. УИХ-ЫН ТОГТООЛУУД:

7 дугаар сард нийт 16 УИХ-ын тогтоол батлагдсан ба тэдгээрийн дийлэнх нь УИХ болон Байнгын хорооны дарга нарыг томилох, чөлөөлөхтэй холбогдсон тогтоолууд байна. Үүнээс бид дараах тогтоолыг онцоллоо.

3.1. ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ТОГТОЛЦОО, БҮТЦИЙН ЕРӨНХИЙ БҮДҮҮВЧИЙГ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ, №13 дугаартай тогтоол

- Энэ тогтоол нь 2024 оны 07 дугаар сарын 10-ны өдөр батлагдсан.

- Энэхүү тогтоолоор дээр дурдсан 23 сайдын эрхлэх асуудлын хүрээ, харьяалах засгийн газрын тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлагийг тодорхойлсон байна.

IV. ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛУУД:

7 дугаар сард нийт 6 Засгийн газрын тогтоол батлагдсан ба тэдгээрээс дараах тогтоолуудыг онцолж байна.

4.1. ТОГТООЛЫН ХАВСРАЛТАД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ (ЗАСГИЙН ГАЗРЫН 2017 ОНЫ 326 ДУГААР ТОГТООЛД), №11 дугаартай тогтоол

- Энэ тогтоол нь 2024 оны 07 дугаар сарын 24-ний өдөр батлагдсан.
- Уг тогтоолоор оффшор бүсэд хамаарах гадаад улс, түүний нутаг дэвсгэрийн жагсаалтаас Сингапур болон Швейцар гэснийг тус тус хассан байна.

4.2. ҮНДЭСНИЙ ХОРОО БАЙГУУЛАХ ТУХАЙ (АЛСЫН ХАРАА-2050), №09 дугаартай тогтоол

- Энэ тогтоол нь 2024 оны 07 дугаар сарын 24-ний өдөр батлагдсан.
- Уг тогтоолоор "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгоор Үндэсний хороог байгуулж, түүний бүрэлдэхүүн болон ажиллах журмыг баталсан байна.

Дээрх агуулгатай холбоотой бусад дэлгэрэнгүй мэдээллийг доорх хаягаар илгээнэ үү.

ALISON & KATE PARTNERS

Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
5-р хороо, Pearl tower A блок 902 тоот
Web: www.akp.mn
E-mail: contact@akp.mn
Tel: 7704-1414, 9511-3680